

ШҮҮГЧИЙН ЭДИЙН ЗАСГИЙН БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДАЛ: ЦАЛИН ХАНГАМЖ, ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА

Шүүгчийн хараат бус байдлын нэг чухал шалгуур үзүүлэлт бол түүний эдийн засгийн бие даасан байдал юм гэдгийг шүүх засаглал, түүний хараат бус байдлын талаарх олон улсын баримт бичгүүдэд онцлон заасан байдаг. Олон улсын хуульчдын холбооноос баталсан “Шүүхийн бие даасан байдлын минимум стандартын тухай Шинэ Делийн журам”, Шүүхийн бие даасан байдал, дэлхийн энх тайвны олон улсын холбооноос гаргасан “Шүүхийн бие даасан байдлын олон улсын стандарт” зэрэг баримт бичгүүд шүүхийн эдийн засаг санхүүгийн бие даасан байдал, түүний дотор шүүгчийн цалин хангамжийн зохистой шийдлийн ач холбогдлыг онцлон дурдсан байна. Шүүгчийн цалин, нөхөн олговор, нэмэгдэл зэргийн талаар гадаад улсын туршлагыг судлах хүрээнд АНУ-ын Холбооны шүүгчдийн

АНУ-ын Холбооны шүүгчдийн цалингийн хэмжээ болон НЭМЭГДЭЛ

АНУ-ын Холбооны шүүгчийн цалинг АНУ-ын Конгрессоос тогтоодог ба аль шатны шүүхийн шүүгч гэдгээс хамааран АНУ-ын Үндсэн хуульд хэсэгчлэн зохицуулсан байна. Тухайлбал, АНУ-ын Үндсэн хуулийн III дугаар зүйлийн 1 дэх хэсэгт АНУ-ын Дээд шүүх болон Конгрессоос шаардлагын дагуу тухай бүр байгуулах доод шатны шүүхүүдийн шүүгчид тогтоосон хугацаанд алба хашсанахаа төлөө цалин дээр нөхөн олговор авах бөгөөд албан тушаалдаа байх хугацаанд нь түүнийг бууруулж болохгүй гэж заасны дагуу АНУ-ын Холбооны шүүгчид цалин дээр нөхөн олговор авдаг байна.¹

Бусад шүүхийн шүүгчдийн цалин, нөхөн олговрын тухай Үндсэн хуулийн шууд хязгаарлалт байхгүй тул цалингийн хэмжээг өөрчлөн тохируулж болдог байна. Гагцхүү хуулиар тогтоосон жагсаалтаар энэ төрлийн цалингийн асуудлыг зохицуулдаг. Шүүгчийн цалингийн талаарх хэлэлцүүлэг хийх, нэмэгдэл олгох, боловсруулалт хийх зэрэг ажиллагаа нь Үндсэн хууль баталснаас хойш гарч эхэлсэн.

Шүүгчийн цалин нь ерөнхийдөө тухайн ажил албатай нь тохирон нэмэгддэг хэдий ч нөхөн олговор олгох асуудал нь тухайн шүүгчийн албан тушаалд тулгуурлан янз бүр байдаг.

1. АНУ-ын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн Холбооны шүүгчдийн цалин

¹ http://en.wikipedia.org/wiki/Federal_judge_salaries_in_the_United_States

1990 оноос хойшхи АНУ-ын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн дагуу томилогдож цалин дээр нөхөн олговор авдаг Холбооны шүүгчдийн жилийн цалинг доорх хүснэгтээр үзүүлэв.²

Он	Холбооны районы шүүхийн шүүгч (district judges)	Тойргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч (Circuit Judges)	Дээд Шүүхийн шүүгч (Associate Justices)	Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч (Chief Justice)
2014 ¹	\$199,100	\$211,200	\$244,400	\$255,500
2013	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2012	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2011	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2010	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2009	\$174,000	\$184,500	\$213,900	\$223,500
2008	\$169,300	\$179,500	\$208,100	\$217,400
2007	\$165,200	\$175,100	\$203,000	\$212,100
2006	\$165,200	\$175,100	\$203,000	\$212,100
2005	\$162,100	\$171,800	\$199,200	\$208,100
2004	\$158,100	\$167,600	\$194,300	\$203,000
2003	\$154,700	\$164,000	\$190,100	\$198,600
2002	\$150,000	\$159,100	\$184,400	\$192,600
2001	\$145,100	\$153,900	\$178,300	\$186,300
2000	\$141,300	\$149,900	\$173,600	\$181,400
1999	\$136,700	\$145,000	\$167,900	\$175,400
1998	\$136,700	\$145,000	\$167,900	\$175,400
1997	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1996	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1995	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1994	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1993	\$133,600	\$141,700	\$164,100	\$171,500
1992	\$129,500	\$137,300	\$159,000	\$166,200
1991 ²	\$125,100	\$132,700	\$153,600	\$160,600
1990	\$96,600	\$102,500	\$118,600	\$124,000

² <http://www.uscourts.gov/JudgesAndJudgeships/JudicialCompensation/judicial-salaries-since-1968.aspx> болон http://www.fjc.gov/history/home.nsf/page/judges_salaries.html

Дээрх тоо нь, өөрөөр заагаагүй бол, 28 U.S.Code § 5, 44 (d), 135, and/or 461-ийн дагуу гарсан бүх нэмэгдэл нь жил бүрийн цалингийн өөрчлөлтөөс хамаарна.

Тайлбар 1: 2014 оны хувьд АНУ-ын хууль 28 U.S. Code § 44(d)-д тойргийн шүүхийн шүүгчдийн томилгоо, бүрэн эрхийн хугацаа, оршин суух газар, цалингийн талаар, тус хуулийн 461 дүгээр хэсгийн дагуу өөрчлөгдсөн 1967 оны Холбооны Цалингийн тухай хууль (2 U.S.Code 351-361) –ийн 225 дугаар хэсэгт заасны дагуу тухайн жилийн тогтоогдсон хувиар тойргийн шүүхийн шүүгч (давж заалдах шатны шүүгч) тус бүр цалин авна гэж заасан байна. Мөн түүнчлэн АНУ-ын хууль 28 U.S. Code § 135-д заахдаа тус хуулийн 461 дүгээр хэсгийн дагуу өөрчлөгдсөн 1967 оны Холбооны Цалингийн тухай хууль (2 U.S.Code 351-361) –ийн 225 дугаар хэсэгт заасны дагуу тухайн жилийн тогтоогдсон хувиар Холбооны районы шүүхийн шүүгч (district judge) тус бүр цалин авна гэж заасан байна.³

Тайлбар 2: 1991 оны эдгээр цалин нь 2 тусдаа өөрчлөлтийг тусгасан ба 1991 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн хүчин төгөлдөр болсон юм. 1989 оны Ёс зүйн шинэчлэлийн акт (Pub. L. No. 101-194, § 703, 103 Stat. 1716, 1768) –ын дагуу 25 хувийн нэмэгдэл болон 1991 оны төсвийн жилийн амьжиргааны зардлын 3,6 хувийн нэмэгдлийг шүүгч болон бусад захиргааны удирдах албан тушаалтанд олгосон байна.⁴ Эдгээр шийдвэрүүд гарснаар өмнө нь орхигдсон байсан цалингийн өөрчлөлтийг оруулахаар тогтоосон байна.

1990 онд Конгрессын зарцуулалт буюу төсөв нь улс төрийн асуудал болж өөрчлөгдсөнөөс үүдэн, хууль тогтоогчид популист сэтгэлгээгээр өөрсдийнхөө амьжиргааны зардлын нэмэгдлийг болиулсан ба үүнд нь шүүгчид ч хамаарсан байна. Түүнчлэн Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд шүүгчийн цалинг албан тушаалдаа байх хугацаанд нь бууруулж болохгүй тухай үзэл санаанд тулгуурлан, түүнчлэн шүүхийг бусад гүйцэтгэх засаглалын салбаруудын нөлөөллөөс хамгаалахын тулд шүүхийн шийдвэрээр 1990 оноос хойш Конгресс цалингийн автомат өсөлтийг зохисгүйгээр суутган авдаг байсныг тогтоосон.⁵

1989 онд Ёс зүйн шинэчлэлийн актыг шүүхийн болон хууль тогтоогчдийн цалингийн тогтолцоо, процессыг тогтвортой байлгах үүднээс баталсан ба АНУ-ын Конгресс 1995 оноос хойш 6 дахь удаагаа 1989 оны Ёс

³ <http://www.law.cornell.edu/uscode/text/28/44>

⁴ <http://www.law.cornell.edu/uscode/text/28/44>

⁵ <http://www.nationaljournal.com/congress/court-rulings-mean-judges-will-get-an-extra-1b-in-pay-and-benefits-20140924>

зүйн шинэчлэлийн актын дагуу олгох ёстой шүүгчийн жилийн цалингийн амьжиргааны өртөгийн нэмэгдэлийг суутган авсан байна. Шүүгчид Дээд шүүх хүртэл эдгээр нэмэгдлийг олгохгүй байгаа нь Үндсэн хууль зөрчиж байгаа тухай давж заалдсан гомдолыг 3 удаа гаргасан байна. Хамгийн сүүлийн жишээ гэхэд Beer болон бусад АНУ-ын эсрэг гаргасан нэхэмжлэл (Beer et al v. United States) юм.⁶

Beer болон бусад АНУ-ын эсрэг гаргасан нэхэмжлэлтэй холбоотой хэрэгт одоогийн болон хуучны Холбооны шүүгчид нэхэмжлэгчээр Холбооны нэхэмжлэлийн шүүх (Court of Federal claims)-д хандаж, шүүгчийн цалин багасгаж, шүүгчийн нэмэгдэл цалин болох 1989 оны Ёс зүйн шинэчлэлийн актын дагуу авах ёстой байсан амьжиргааны өртөгийн нэмэгдэлийг олгохыг болиулсан нь Үндсэн хуулийг зөрчсөн талаар зарга мэдүүлсэн байна. Хариуцагч тал болох АНУ-ын Холбооны засгийн газраас гомдлыг хэрэгсэхгүй болгохоор хүсэлт тавьсан ба 2009 оны 10 дугаар сарын 16-нд Холбооны нэхэмжлэлийн шүүх хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Улмаар нэхэмжлэгчид давж заалдсан ба шүүхийн бүрэн бүрэлдэхүүнтэйгээр хэргийг хянан шийдвэрлүүлэхээр хүсэлт тавьсан байна.⁷ АНУ-ын Холбооны тойргийн давж заалдах шатны шүүх бүрэн бүрэлдэхүүнээрээ хянан хэлэлцэж шийдвэрээ гаргасан⁸ ба Конгресс нь 140 дүгээр хэсгийн (Section 140 of P.L. 97-92. Section 140) буруу тайлбарт үндэслэн 1995, 1996, 1997 болон 1999 онуудад Холбооны шүүгчид олгох ёстой байсан амьжиргааны өртөгийн нэмэгдэлийг олгохыг болиулсан, түүнчлэн 2001 болон 2010 онуудад амьжиргааны өртөгийн нэмэгдэлийг суутган авсан нь Үндсэн хуульд заасан цалин олговор олгох тухай зүйл заалтыг зөрчсөн гэж үзсэн байна.⁹ Beer-ийн хэргийг холбогдох нэхэмжлэгчид нөхөн олговол зохих мөнгөн дүнг дахин тооцуулж шийдвэрлүүлэхээр Холбооны нэхэмжлэлийн шүүх (Court of Federal claims)-д буцаасан байна.¹⁰ Энэ талаар Холбооны засгийн газар Дээд шүүхэд давж заалдах хүсэлтийг 2014 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд гаргаж болох тухай дурдсан ба Холбооны засгийн газрын Хууль зүйн яам (Department of Justice) –ийн ерөнхий өмгөөлөгч (Attorney general) АНУ-ын Төлөөлөгчдийн Танхим (House of Representatives)-д хандаж

⁶ Bruce Moyer. The Beer Case: Less Filling, More Judicial Pay The Federal Lawyer, May 2012, p.6

⁷ <http://www.ca9c.uscourts.gov/images/stories/opinions-orders/10-5012om.pdf>

⁸ <http://sblog.s3.amazonaws.com/wp-content/uploads/2013/02/United-States-v-Beer-Petition.pdf>

⁹ <http://www.law.cornell.edu/supremecourt/text/425/130>

¹⁰ http://www.americanbar.org/publications/governmental_affairs_periodicals/washingtonletter/2012/december/classaction.html

энэ хэрэгт АНУ-ын Засгийн газар АНУ-ын Дээд шүүхэд давж заалдахгүй тухайгаа бичгээр илэрхийлсэн байна.¹¹

Улмаар Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Жонн Робертсоос эхлэн 2000 гаруй Холбооны шүүгчид 1 тэрбум орчим ам.долларыг цалиндаа хувааж авч, дараагийн 10 жилд ашгийг нь хүртэхээр болсон байна. Конгрессын төсвийн албаны дарга Дуглас Элмэндорф “Эдгээр шийдвэр болон холбогдох захиргааны үйлдлийн үр дүнд ихэнх шүүгчид цалингийн автомат өсөлт болон жил бүрийн нэмэгдэл, түүнчлэн өмнө авах ёстой байсан цалингийн автомат нэмэгдлийн буцаан олголтыг авна” гэж хэлсэн байна.¹²

Холбооны шүүгчид энэ шийдвэрийн дагуу үр ашгийг нь хүртэж эхэлсэн ба 2014 оны 1 дүгээр сарын 1-ээс эхлэн тэдний цалинг 14 хувь буюу өмнөх жилүүдийн олгогдоогүй нэмэгдлийг нэмсэн байна.

Үр дүнд нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалинг 199,100 ам.доллар, Тойргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн цалинг 211,200 ам.доллаар, Дээд Шүүхийн шүүгчийн цалинг 244,400 ам.доллар, Дээд Шүүхийн Ерөнхий шүүгчийн цалинг 255,500 ам.доллаар тогтоосон байна. Эдгээр цалингийн түвшинг 2014 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн бүх холбооны засгийн газрын ажилтан, албан хаагчдад 13655 дугаартай Гүйцэтгэх тоот (Executive Order No. 13655 (Dec. 23, 2013)) -ын дагуу олгож эхэлсэн амьжиргааны зардлын нэмэгдэл болох 1 хувийн дагуу өөрчлөн нэмэгдүүлсэн байна.

2. Холбооны бусад шүүхийн шүүгч буюу АНУ-ын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлд хамаардаггүй шүүгчдийн цалин, олговор

- *Магистратын шүүгч*

1988 оноос хойш АНУ-ын Шүүхийн Зөвлөгөөн (Judicial Conference of the United States) –өөс магистратын шүүхийн шүүгчдийн цалинг тогтоодог ба энэ нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалингийн 92 хувиас хэтэрч болдоггүй байна.¹³

- *Дампуурлын хэргийн шүүгч*

¹¹ <http://www.justice.gov/sites/default/files/oip/legacy/2014/07/23/10-29-2013.pdf>

¹² <http://www.nationaljournal.com/congress/court-rulings-mean-judges-will-get-an-extra-1b-in-pay-and-benefits-20140924>

¹³ "History of the Federal Judiciary". Federal Judiciary Center. Retrieved 11 January 2014.

1988 оноос хойш дампуурлын хэргийн шүүгчид нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалингийн 92 хувьтай тэнцэхүйц хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг байна.¹⁴

- *Татварын хэргийн шүүхийн шүүгч*

Татварын хэргийн шүүхийн шүүгч нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалинтай адил хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг байна.¹⁵

- *Холбооны нэхэмжлэлийн шүүхийн шүүгч (Court of Federal claims judges)*

Холбооны нэхэмжлэлийн шүүхийн шүүгч нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалинтай адил хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг байна.¹⁶

- *Зэвсэгт хүчний давж заалдах шатны шүүхийн шүүгч*

Зэвсэгт хүчний давж заалдах шатны шүүх Холбооны тойргийн давж заалдах шүүхийн шүүгчийн цалинтай адил хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг байна.¹⁷

- *Ахмад дайчдын нэхэмжлэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгч*

Ахмад дайчдын нэхэмжлэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нь Холбооны районы шүүхийн шүүгчийн цалинтай адил хэмжээний нөхөн олговрыг цалин дээр авдаг байна.¹⁸

ШҮҮХИЙН СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТЫН ХҮРЭЭЛЭН

¹⁴ http://www.fjc.gov/history/home.nsf/page/js_5.html болон "28 U.S.C. § 153". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.

¹⁵ "26 U.S.C. § 7443". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.

¹⁶ "28 U.S.C. § 172". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.

¹⁷ "10 U.S.C. § 942". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.

¹⁸ "38 U.S.C. § 7253". Cornell University Law School. Retrieved 11 January 2014.